



БАГА ХЭМЖЭЭНИЙ ЦӨМИЙН МАТЕРИАЛЫН ШИНЭЧИЛСЭН ПРОТОКОЛЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1 Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол улс Иж бүрэн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны гэрээнд (Comprehensive Safeguards Agreement-1972) 1972 онд, тус гэрээний нэмэлтэд (Additional Protocol) 2003 онд тус тус нэгдэн орсон.

Улсын Их Хурлаас 2000 онд Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг баталж, улмаар манай улс Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээний баталгааг хэрэглэх тухай Нэмэлт протоколд 2001 онд гарын үсэг зурж, Улсын Их Хурал 2003 онд соёрхон баталсан.

“Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 60 дугаар тогтоолд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт өөрчлөлт болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох талаар холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасан болно.

Иймд дээр дурдсан Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай асуудлыг хэлэлцээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов” гэж шийдвэрлэсэн бөгөөд Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2016 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг протоколыг соёрхон батлах тухай асуудлыг хэлэлцэн дэмжиж, гарын үсэг зурахыг Засгийн газарт зөвшөөрсөн болно.

Цөмийн энергийн комиссын 2022 оны хуралдаанаар хэлэлцүүлэн, Улсын Их Хуралд өргөн барих чиглэл өгсөн. Мөн Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд нэгдэн орох асуудлыг хэлэлцүүлж, хуралдааны 33 дугаар тэмдэглэлд конвенцыг хэлэлцэн дэмжиж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон.

Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг дэмжсэн.

Дээрх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар танилцуулсан бөгөөд УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн дараа хэлэлцэхээр шийдвэрлэсэн.

1.2 Практик үндэслэл, шаардлага

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол нь Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны нэг хэсэг бөгөөд бага хэмжээний цөмийн материалтай болон цөмийн төхөөрөмжгүй улс орнуудад зориулсан хяналт, баталгааны гэрээ юм.

Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээ (цөмийн зэвсэггүй бүсийн гэрээ)-ний 3 дугаар зүйлийн 1 дэх заалтад цөмийн зэвсэггүй улс орнуудыг Иж бүрэн цөмийн аюулгүй байдлын баталгааны гэрээнд нэгдэн орох шаардлагатай гэж заасан болно.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколыг соёрхон батлах тухай асуудлыг тусгана.

Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны газраас Бага хэмжээний цөмийн материалын протоколыг (GOV/INF/276/Annex II-) анх 1970 онд боловсруулсан бөгөөд Монгол Улс тус протоколд 1972 онд гарын үсэг зурсан. Тус агентлагаас уг протоколыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэнээр 2005 онд шинэчилсэн стандарт текст (GOV/INF/276/Mod.1)-ыг баталсан.

2024 оны 09 дүгээр сарын байдлаар “Иж бүрэн цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааны гэрээ”-нд 191 орон, 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар “Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол”-д (Small Quantity Protocol) 63 орон нэгдэн орсон байна.

Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколоор улс орнууд өөрийн эзэмшиж байгаа бүх цөмийн материал (уран, полутони, тори)-ыг Олон Улсын Атомын Энергийн Агентлагт үнэн зөв, бүрэн баталгаажуулан мэдүүлэх үүрэгтэй бөгөөд тус агентлаг нь улс орнуудын мэдүүлэг үнэн зөв, бүрэн гүйцэд, дэлхий дахинд цөмийн бүх материалыг энхийн үйл ажиллагаанд зориулж буй гэдгийг баталгаажуулан дүгнэдэг юм.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн зүйн үр дагавар, ач холбогдол

Хуулийн төсөл батлагдсанаар манай улс Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааг хэрэгжүүлэхэд олон талын дэмжлэг туслалцаа авах боломжтой болно. Тухайлбал, хууль эрх зүйн баримт бичиг боловсруулахад дэмжлэг, зөвлөмж авах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх баталгааг гүйцэтгэх чадавхийг бий болгох, цөмийн материалын хяналтын тооллогын улсын системийн тухай зөвлөх үйлчилгээ авах, хүний нөөцийг чадавхжуулах, дадлагажуулах хөтөлбөрт хамрагдах боломжтой болох юм.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын хууль тогтоомжтой хэрхэн уялдах, шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаархи санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн байх бөгөөд бусад хууль тогтоомжтой уялдсан байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй.